



ОЛОН ТАЛЫН ОРОЛЦООТ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙХ УДИРДАМЖ

- Ажлын нэр:** Сургуулийн удирдлага, багш, эцэг эхчүүдийг оролцуулсан сургуулийн түвшний олон талт хэлэлцүүлэг
- Зорилго:** Хийгдсэн судалгаа, мониторингийн урьдчилсан үр дүнгүүдийг танилцуулж баталгаажуулах, зөвлөмжүүдээ боловсронгуй болгох
- Хугацаа:**

Үндэслэл

Бид боловсролын тогтолцоо бүхэлдээ бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрдөг, хүн бүрийн тусгай хэрэгцээнд нийцсэн, сурагч бүр өөрийн мэдлэг чадвараа ахиулан амжилттай суралцах боломжтой сургалтын орчныг бүрдүүлэх нь боловсролын гол зорилго байх ёстойг гэж үздэг. Тиймээс “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл 2020 онд боловсролын бодлогын гадна орхигдох, заавал эзэмших боловсролоос гадуурхагдах эрсдэл өндөртэй эмзэг бүлгүүдийн (үндэстний цөөнхийн, жендерт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн хохирогч хүүхдүүд, алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм эдийн засгийн статусын хувьд доогуур өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй) хүүхдүүдийн суралцахад тулгардаг саад тотгор болон тэдгээр бүлгүүдийн хүүхдүүдийн тусгай эрэлт хэрэгцээний талаар судалгаа хийж, тайлангууд гарсан билээ.

Нэгдсэн үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО) тэгш хамруулах боловсролыг “Бүх суралцагчдын нийгэм, соёл, боловсролын үйл ажиллагаа дахь тэгш оролцоог хангах, боловсролын гаднах болон доторх бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхалтыг бууруулах замаар сурагч бүрийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн боловсролын үйлчилгээг хүргэх үйл явц” (UNESCO, 2008) хэмээн тодорхойлсон байна.

Судлаачдын боловсруулсан тайлан мэдээлэл болон гаргасан бодлогын зөвлөмжүүдийг судалгаанд оролцсон орон нутгийн иргэд, тухайлбал, сургуулийн удирдлага, багш, эцэг эхчүүдээр хэлэлцүүлж, зөвлөмжийг нарийвчлах, олон талын санаа бодлоор баяжуулах, баталгаажуулах шаардлагатай гэж үзлээ. Хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг

судалгааны тайлангийн хамт холбогдох төрийн байгууллагуудад танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг үндэсний түвшинд зохион байгуулж, энэ үйл явцад өөрсдийн хувь нэмрээ оруулахаар Боловсрол эвслээс төлөвлөөд байна.

Хэлэлцүүлгийн зорилго

Энэхүү хэлэлцүүлгийг зохион байгуулснаар сургуулийн хамт олны олон талыг төлөөлсөн оролцогчдод судалгааны үр дүнгүүдийг мэдээлэх, боловсролын бодлогоос үлдэх, боловсролоос гадуурхагдах эрсдэл өндөртэй эмзэг бүлгийн (үндэсний цөөнхийн, жендерт суурилсан хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн хохирогч хүүхдүүд, алслагдсан сум дүүрэг, хороодын нийгэм эдийн засгийн статусын хувьд эмзэг байдал байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй) хүүхдүүдийн хэрэгцээг ойлгох, мэдэх, тэдгээр бүлгийн хүүхдүүдийн боловсролын болон бусад тусгай хэрэгцээний талаар оролцогч талууд өөрсдийн сургуулийн түвшинд шийдэл гаргахаар харилцан тохиролцох, санаачилга гаргах, улмаар тэгш хамруулсан соёлтой, өдөр тутмын үйл ажиллагаа нь сургууль болж өөрчлөлт гаргахад хүчээ нэгтгэхэд чиглэнэ.

Оролцооны зарчим

Эрх тэгш байдал: Бүх оролцогчдын хувьд оролцооны эрх тэгш байдлыг үнэлэх зайлшгүй шаардлагатай. Эрх мэдэлтэй буюу дуу хоолойгоо илэрхийлж чаддаг удирдлага, багш нарыг тодорхой хэмжээнд хязгаарлаж, эрх мэдэл багатай, магадгүй эцэг эхчүүд- оролцогчдод тусгай анхаарал хандуулан оролцоог дэмжих нь чухал. Хүйс, үндэс угсаа, бүс нутаг болон бусад шинж чанарын онцлогт тулгуурлан тэгш оролцоог хангах нь чухал. Бүх оролцогчдад бүх зүйл хүртээмжтэй байна уу гэдгийг шалгах хэрэгтэй, жишээлбэл бүх хүн интернетээс файл татаж авч чадахгүй тул судалгааны тайланг яаж бүх хүн хэлэлцүүлгийн өмнө уншиж саналаа хэлэхээр бэлтгэж ирэх вэ гэдэгт анхаарах.

Уян хатан байдал: Уян хатан байдал бол хэлэлцүүлэг амжилттай явагдахад чухал нөлөөтэй. Гэсэн хэдий ч тодорхой төлөвлөгөө, ил тод харилцаа хэрэгтэй болдог, учир нь оролцогчдын дуу хоолойгоо илэрхийлэх чадавх харилцан адилгүй тул хэлэлцүүлэгт зориулж хуваарилсан цагаа багасгахгүй байх, үг хэлж байгаа хүмүүст цаг барих шаардлага тавих, илтгэл мэдээлэл хийгчдэд цаг минутыг сануулах аргуудыг хэрэглэх нь чухал. (Ихэнхдээ цаг хоцорч эхлэнгүүт хэлэлцүүлгийн цагийг багасгадаг)

Тэгш хамруулсан байдал: Уг хэлэлцэх асуудал өөрт нь нөлөөлдөг болон нөлөөлөх магадлалтай хүн бүр оролцох нь амжилттай хэлэлцүүлгийн хамгийн гол багана. Холбогдох хэлэлцүүлэгт ашиг сонирхолд нь нөлөөлөх бүх талуудын хэрэгцээг багтаах хэрэгтэй. Тухайн хэлэлцүүлэгт хамгийн их хамааралтай гол бүлэгтэй ярьж зөвлөлдөх хэрэгтэй. Хэлэлцүүлэгт оролцох сонирхолгүй байгаа хүмүүсийг мотивацижуулахад анхаарч, тухайн хүнийг хэлэлцүүлэгт оролцоход дэмжлэг үзүүлэх, шаардлагатай чадавхийг бэхжүүлж оролцоог хангахад анхаарах шаардлагатай.

Суралцах боломж олгох: Үйл явцийн туршид суралцах хандлагыг баримтлах нь чухал бөгөөд стартегийн ач холбогдолтой. Хамгийн боломжит шийдлийг олох, үйл ажиллагааг төлөвлөхийн тулд бүх хүн өөрт нь нөлөөлөх тухайн асуудлын талаар мэддэг, боломж болон саадын талаар ойлголттой болгоход хэлэлцүүлэг чиглэх хэрэгтэй. Бүх хүн шийдэл хэлэх боломжгүй ч ойлголт мэдлэгээ нэмэгдүүлж, хэлэлцүүлэгт оролцох чадварт суралцах зэрэг дагавар үр нөлөө гарч байдаг.

Өмчлөл: Үйл явц болон үр дүнг хамт бүтээх нь дундын өмчлөл болон нэгдмэл амлалтыг бий болгодог. Өөрөөр хэлбэл сургуулийн хамт олныг оролцуулж байгаагийн цаад зорилго нь тэд хамтдаа сургууль дээрээ өөрчлөлт гаргах ёстой. Судалгаа хийгээд тайлан гаргаад зогсох биш, асуудлаа олж хараад шийдэхийн төлөө хамтдаа ажиллах зориг эрмэдлэл төрүүлэхэд анхаарна. Хэлэлцүүлгийг дүгнэхдээ оролцогчдын сургуулийн түвшинд хамтран хийж болох гэсэн санаануудыг онцлон хэлж, арга замыг чиглүүлж өгөх нь чухал.

Ил тод байдал: Юу хийх, хэн ирэх, ямар зорилготой байх зэрэг мэдээллээ талуудын төлөөлөлтэй хуваалцах нь чухал. Оролцогч талууд нэг талбар дээр хамт байхад тэд хэн оролцох гэж байгааг харж, ямар үр дүн гарахыг харж байж үйл явцад оролцоно. Хэлэлцүүлгийн талаарх бүх мэдээллийг сургуулийн захиргаа (захирал), багш нар (багш нарын өрөөнд зар тавих, сургалтын менежерээс оролцох багш нарын нэрийг авах гэх мэт), Сургуулийн эцэг эх, багшийн холбоонд хүргэж (эцэг эхийн зөвлөлийн даргад мэдэгдэх, сургуулийн нэг давхарт зар тавих, бүртгүүлэх хуудас тавих гэх мэт), биеэр уулзаж тохиролцоно.

Хамрах хүрээ

Улаанбаатар хот болон орон нутгийн ЕБС-ын 10 сургууль

Хэлэлцүүлэг явагдах зохион байгуулалт

Тогтвортой хөгжлийн 4 дэх зорилго болох “Тэгш хамран сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол, бүх нийтийг насан туршийн боловсролоор хангах”, түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бусад дэд зорилтуудын хэрэгжилтийг үнэлэхдээ тухайн улс орны хамгийн маргиналь бүлэг боловсролын үйлчилгээг авч чадаж буй эсэх шалгуур үзүүлэлтийг авч үздэг. Угтаа боловсролын үйлчилгээний гадна үлдэх хамгийн өндөр эрсдэл бүхий бүлгүүдэд боловсрол үйлчилгээ хүрч чадаж байвал тухайн улсын боловсролын үйлчилгээ бүх иргэддээ хүртээмжтэй байна гэж дүгнэдэг. Боловсрол бүх нийтэд хүртээмжтэй байх нь Тогтвортой хөгжлийн бусад зорилтыг хангах суурь, хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл юм.

Тэгш хамруулан сургах боловсрол нь боловсролын салбарын урт хугацааны бодлого, түүний хэрэгжилт бөгөөд боловсролын хүртээмж, оролцоо, сургалтын үр дүнгийн ялгаатай болон тэгш бус хандлага, ялгаварлан гадуурхалт, хязгаарлагдмал байдлын бүх хэлбэрийг шийдвэрлэхэд бүх оролцогч талууд тасралтгүй хамтран ажиллах үйл явц юм.

Хэн оролцох вэ?

Энэхүү үйл явцын нэг хэсэг болсон уг хэлэлцүүлэгт Сургуулийн захиргаа, багш, эцэг эхийн төлөөлөл оролцоно. Мэдээж сургуулийн захиргаанаас цөөн, багш нар тодорхой хэмжээнд,

эцэг эх давамгай олонх байх зэрэг аль болох олон талын оролцоог хангасан байхаар зохион байгуулна. Тус тусад нь биш хамтад нь зохион байгуулах нь чухал.

Хэлэлцүүлэгт 30-50 оролцогч байна. Үүнд:

1. Сургуулийн удирдах албан тушаалтан,
2. Сургуулийн багш нарын төлөөлөл
3. Эцэг эхийн төлөөлөл
4. Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл,
5. Сурагчдын төлөөлөл
6. Төрийн албан хаагчдын төлөөлөл (Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Хүүхэд хамгааллын хамтарсан баг, Боловсрол Соёлын газар зэрэг)
7. Хэвлэл мэдээллийн төлөөлөл
8. Насан туршийн боловсролын төв

Хэлэлцүүлгийн хугацаа ямар байвал тохиромжтой вэ?

Хэлэлцүүлэг хагас өдөрт багтвал тохиромжтой. Хэлэлцүүлгийн хөтөлбөрийг урьдчилан гаргаж, илтгэл мэдээлэл хийх, нээлт хаалт хийх, чиглүүлэх зэрэг хүмүүсийг урьдчилан тогтож хөтөлбөрт тусгана. Хэлэлцүүлгийн чиглүүлэгч хэлэлцүүлгийн дэгийг урьдчилан сануулж, хэлэлцүүлгийн хөтөлбөрт заасан цагийг бариулж, давамгай байгаа оролцогчдыг эвтэйхэн зохицуулж, асуудлаас хальвал зогсоож, оролцогчдыг талцан зөрчилдөхөөс сэргийлж, нийтлэг зүйлсийг олж харан чиглүүлэх, зохион байгуулагч өөрөө аль нэг талыг барилгүй дундын байр сууринд байх хариуцлага хүлээнэ.

Хаана хийх вэ?

Сургуулийн байрнаас өөр газар хийвэл зүгээр. Иргэний танхим, иргэдийн уулзалт, хурал хийгддэг олон нийтийн хүрч очих боломжтой, хэлэлцүүлэг чанартай хийх нөхцөл бүрдсэн газар байвал зүгээр. Сургуулийн байранд хийхэд удирдлага, багш нар хэлэлцүүлгээс орж гарах, хичээл завсарлах хонх дуугарах зэргээр саад учирдаг.

Урьдчилж бэлдэх зүйлс

Судалгааны тайланг урьдчилан оролцогчдод хүргэх зохион байгуулалт хийвэл зүгээр, хэлэх санаагаа бэлтгэж ирэх нь хэлэлцүүлгийн чанарт нөлөөлнө. Хэвлэхэд олон хуудас материал байгаа тул зөвлөмжийг хэвлэн тараах, **и-мэйлээр явуулах, фейсбүүк группт тавих** зэргээр оролцогчдод бүрэн хүргэх арга хэмжээ авна.

Оролцогчдын жагсаалтыг урьдчилан гаргаж, нэг өдрийн өмнө утас, мессежээр цагтаа ирэхийг сануулна. **Хэлэлцүүлгийн өдөр оролцогчдын нэр, мэдээллийг багтаасан хүснэгтийг бэлтгэж, цахим хуралд оролцогчдын бүртгэлийг хийнэ.**

Хэлэлцүүлгийн үеэр баримтжуулалтад анхаарна уу. Хэлэлцүүлгийн явцыг тэмдэглэн бичих, эсвэл протокол хөтлөх хүнийг тусгайлан ажилллуулна.

Цахимаар хийж байгаа тохиолдолд бичлэг хийж протоколоо дараа нь хөтөлж болно. Зураг чанартай сайн авах хүнийг хариуцуулах бөгөөд оролцогчдыг камераа нээж зургаа авахуулахыг хүсээрэй.

Орон нутгийн хэвлэл мэдээлэлд урьдчилан мэдэгдэж, зохион байгуулж байгаа цахим үйл ажиллагаандаа оролцуулж, судалгааны үр дүнгүүдээ өгч сурталчилж болно.

Хэлэлцүүлгийн хөтөлбөр

Хэлэлцүүлгийг цахимаар зохион байгуулах тохиолдолд нийт цагийг 2 цагаас хэтрүүлэхгүй байхад анхаарна уу.

1. Хэлэлцүүлгийг зохион байгуулагч тал нээж үг хэлэх – судалгааны талаарх эхний танилцуулга болон судалгааны мэдээлэл цуглуулахад оролцсон талуудад талархах (мэдээлэл цуглуулахад оролцоогүй бол хаанаас мэдээлэл цуглуулсан болохыг урьдчилан харж танилцуулах)
2. Мэдээлэл цуглуулахад оролцоогүй ч гэсэн тухайн судалгааны үр дүн монгол орны хаана ч ижил байгаа гэдгийг бусад судалгаа баталж буйг мэдээлэх
3. Ковид 19 цар тахлаас шалтгаалсан хоцрогдол, хоол тэжээлийн хомсдол үүссэн өнөө үед амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн хүүхдүүдэд анхаарах шаардлагатайг сануулах
4. Судалгааны үр дүнг танилцуулах - ППТ-г Боловсрол эвслээс өгнө
5. Судалгааны талаар асуулт хариулт - ойлгохгүй, лавлах, тодруулах зүйлээ асуугаарай гэж хэлнэ
6. Судалгааны үр дүн дээр нэмж хэлэх - хамтран ажиллах, сургуулийн түвшинд хамтран хийх, санал зөвлөмж, сэтгэгдэл хэлэх боломжийг оролцогчдод олгох
7. Хаалтын үгийг заавал хэлэх, нийт оролцогчдод талархал илэрхийлж, дахин хамтран ажиллахыг ерөөх.

(Хавсралтаар загвар хөтөлбөр, судалгааны танилцуулга ппт-г хавсаргав.)

Хүлээгдэж буй үр дүн

- Эвслээс явуулсан судалгааны үр дүнг баталгаажуулах,
- Олон талын санал бодлыг тусган судалгааны санал зөвлөмжүүдийг баяжуулах,
- Хэлэлцүүлгийн тайланг, баримтжуулалтын хамт авах

Хэлэлцүүлэг зохион байгуулах санхүүжилт

Батлагдсан төсвийн дагуу санхүүжилтийг олгох ба санхүүгийн тайланг гүйцэтгэлээр хавсаргасан зааврын дагуу Боловсрол эвслийн нягтлан бодогчид хүлээлгэн өгнө.